

Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

Мэдээллийн эмхэтгэл No.35

DPUB төслийн багийнхны мэндчилгээ



Мэргэжилтэн
Тэрүя Эми

“Хөгжлийн бэрхшээл нь хүрээлэн буй орчин, хүмүүсийн хандлагаас болж үүсдэг”. Би Монгол Улсад 4 жил ажиллах хугацаандаа энэ ойлголтыг дэлгэрүүлэх чиглэлээр ажиллалаа. Шатнууд налуу зам байсан бол, цахилгаан шат дуут тайлбартай байсан бол... Манай төслийн зүгээс түгээж байсан эдгээр мессэжүүд Монголын ард түмэнд хүрсэн гэдэгт итгэлтэй

байна. Мөн би өөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэнийхээ хувиар та бүхэнд хандаж “Нөлөөллийн үйл ажиллагаанд төгсгөл байхгүй” гэсэн үгийг хэлэхийг хүсэж байна. Учир нь дэд бүтцийн хүртээмжийг сайжруулсан ч хүмүүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харах өнцөг, ойлголтын саадыг өөрчилж, арилгана гэдэг тийм ч амар зүйл биш. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань ч өөрсдийн бие эрхтний бэрхшээлээсээ болоод нийгмийн амьдралд оролцохоос татгалзаж байгаа юм биш биз? Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийнхэн гээд бүхий л хүмүүст чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаанууд төсөл дууссаны дараа ч үргэлжилнэ гэдэгт найдаж байна.



Ахлах зөвлөх
Чиба Хусео

JICA/DPUB төсөл 4 жилийн хугацаанд амжилттай хэрэгжиж дууслаа. Энэ бол Монгол Улсын Засгийн газар, ХБИ-ийн ТББ-ууд болон бусад холбогдох хүмүүсийн ойлголцол, хамтын ажиллагааны үр дүн гэж бодож байна. Миний бие 2016 онд томилогдож ирэхдээ өөрийн хэрэгжүүлж чадах зүйл юу вэ гэдэг тал дээр санаа зовж байсан боловч Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийн лавлах номыг хэвлэх, хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээллийг шинэчлэх, барилгын хяналтын систем гэх мэт дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах ажлууд, мэдээллийн хүртээмжийн үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын ойлголтыг түгээх болон хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын ойлголтыг дэмжих, хөгжлийн бэрхшээлийн талаарх цуврал хичээлийг зохион байгуулах зэрэг олон үйл ажиллагааг та бүгдтэй хамт хэрэгжүүлж чадлаа. Гэхдээ бүх хүмүүс амьдрахад таатай нийгмийг бий болгохын тулд тасралтгүй үйл ажиллагаа явуулах шаардлагатай. DPUB төсөл 2020 оны 5 сарын 30-нд дуусгавар болж байгаа ч та бүхэнтэй дахин хамтарч үйл ажиллагаа явуулахыг чин сэтгэлээсээ хүсч байна.

Миний бие Исобэ Ёоко мэргэжилтнээс ажлаа хүлээн авч, 2018 оны 5 сараас эхлэн 2 жилийн хугацаанд Монгол Улсад ажилласан. Энэ хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой мэдээллийн судалгаа шинжилгээнээс гадна төслийн зохицуулалтын ажлыг хариуцаж байсан. Нэг жишээ дурдахад “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа” мэдээллийн лавлах номын 2 болон 3 дахь хэвлэлд хамтарч ажилласан бөгөөд цаашид ХНХЯ тус номыг үргэлжлүүлэн хэвлэнэ гэдэгт итгэлтэй байна. Мөн “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо” гэх мэт хөгжлийн бэрхшээлийн статистикийн үндсэн мэдээллүүдийг сайжруулахад хамтарч ажилласан. Энэ 2 жилийн хугацаанд Монголын талын холбогдох хүмүүсийн хичээл зүтгэлийн ачаар олон үйл ажиллагааг хэрэгжүүлж чадсан гэж бодож байна. Энэ туршлага маань миний хувьд ч маш том хөрөнгө болж чадсан. Хэдийгээр төсөл маань Улаанбаатар хотод төвлөрч үйл ажиллагаа явуулсан ч томилолт болон хувийн шугамаар хөдөө орон нутаг руу аялах боломж гарч, Монголд бүр илүү хайртай болсон юм. Иймд төсөл дууссаны дараа ч Монгол Улстай ямар нэгэн хэлбэрээр холбоотой ажиллахыг хүсэж байна. Энэ дашрамд та бүхэнтэй дахин уулзах өдрийг тэсэн ядан хүлээж байгаагаа уламжилъя. Баярлалаа.



Мэргэжилтэн
Хигашида Масатэру

JICA/DPUB төсөл 2016 оноос хойш 4 жилийн хугацаанд амжилттай хэрэгжиж дууслаа. Монгол Улсын Засгийн газар, Японы ЖАЙКА байгууллага хамтран хэрэгжүүлсэн тус төсөл нь хүний нөөцийг бэхжүүлэх, нийгмийн ойлголт, хандлагыг сайжруулах зорилгоор олон үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Монгол ажилчдын хувьд өдөр тутмын үйл ажиллагаа, харилцаа холбоо, бичиг баримт боловсруулах гээд бүх ажлыг япон, монгол хэлээр хослуулан гүйцэтгэх үүрэгтэй байсан тул өндөр хариуцлага хүлээсэн 4 жил байлаа. Мөн урд өмнө нь ажиллаж байгаагүй салбар байсан тул төр, ТББ болон япон мэргэжилтнүүдийг холбох гүүр болон ажиллахдаа их зүйлийг сурч, өсөж дэвшиж чадлаа. Бид бүхнийг дэмжин ажилласан та бүхэндээ маш их баярлалаа. Нийгмийн хандлага, ойлголтыг өөрчлөх нөлөөллийн ажлууд цаашид ч үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна.



Зүүн гар талаас Х.Энхжин, Г.Амаржаргал, Ц.Одгэрэл,
Д.Даваажав

DPUB төслийн хамгийн сүүлийн JCC хурал (Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал) 5-р сарын 8-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн хурлаар 4 жил хэрэгжсэн үйл ажиллагааны тайлан болон ХНХЯ, бусад холбогдох яамдууд, ТББ-уудын цаашдын үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөний талаар ярилцсан нь маш ач холбогдолтой байв. Энэ 4 жилийн хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл, ХБХХЕГ байгуулагдсанаас гадна Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа номыг хэвлэх, хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээллийг сайжруулах, саадгүй байдлыг дэмжих барилгын хяналтын тогтолцоог сайжруулах, шинэ стандартыг батлах, Хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулж хэлэлцэх,



мэдээллийн хүртээмжийг дэмжих зэрэг олон ахиц дэвшил гарчээ. Мөн “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт” өргөн хүрээнд зохион байгуулагдсан нь маш үр дүнтэй байв. Тус сургалтад хэдийнээ 10,000 гаруй хүн хамрагдаад байгаа бөгөөд “хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт нь Монгол Улсад бага багаар энгийн ойлголт болон түгэн дэлгэрч байна. Нөгөөтэйгүүр одоохондоо 10,000 хүн л хамрагдсан байгаа учраас цаашид DET сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах шаардлагатай гэж бодож байна. Монгол Улсад хүн бүр “хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ыг мэдээжийн ойлголт хэмээн хүлээн авдаг болгохын төлөө DET сургагч багш нар маань идэвхтэй үйл ажиллагаа явуулна гэдэгт найдаж байна.



DPUB төслийн 8 дахь удаагийн JCC хурал (Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал) 5-р сарын 8-нд болсон. Тус өдөр ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр JICA DPUB төслийг ахлах зөвлөл Чибэ Хисаог “НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” тэмдгээр шагнаж, үнэмлэх олгосон нь JICA DPUB төслийн хамт олны хувьд нэр төрийн хэрэг боллоо. Өнөөг хүртэл бидэнтэй хамтран ажиллаж ирсэн төр, ТББ-уудын хамт олонд талархал илэрхийлье. Чибэ мэргэжилтэн “Монгол Улсад 4 жил ажиллах хугацаанд хөгжлийн бэрхшээлийн салбарт бага ч болов хувь нэмэр оруулахын төлөө ажиллаж ирсэн. Энэхүү хичээл зүтгэлийг минь үнэлж, шагнал гардуулсанд маш их баяртай байна” хэмээн сэтгэгдлээ илэрхийллээ.

DPUB Холбоо барих хаяг

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

Цахим хуудас: [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

И-мэйл: dpub.jica@gmail.com